



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/208

Улаанбаатар хот

Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба
тодорхойлолт 08-д өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт 08-ын 2 дугаар хавсралтын 3434 нэгж бүлгийг Шеф тогооч, 1341 нэгж бүлгийг Хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээний менежер гэж өөрчлөн тус нэгж бүлэгт 1341-04 Хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээний менежер, 1341-05 Өдөр өнжүүлэхийн менежер, 2423 нэгж бүлэгт 2423-18 Ажлын байрны дадлагажуулагч, 5322 нэгж бүлэгт 5322-15 Хөгжлийн бэрхшээлтэй хүний туслах гэж тус тус нэмэн, 6129-20 Туслах малчин индекс/кодыг хүчингүй болгосугай.

2. Зам тээврийн салбарт хамаарах 2320-116 Багш, жолооны /усан замын тээврийн хэрэгслийн/, 2144-47 Инженер /агаарын хөлгийн гадаргуугийн цанталт арилгах, мөстөлтөөс хамгаалах шингэн цацагч автомашины/, 3153-18 Шалгалтын нислэгийн шалгагч инженер, 3154-13 Инженер /нислэгийн журам зохиогч/, 3154-14 Ерөнхий нислэгийн удирдагч, 3154-15 Ахлах нислэгийн удирдагч, 3154-16 Нислэгийн удирдагч, 3154-17 Зохицуулагч /эрэн хайх, авран туслах, мэдээлэл зохицуулах хэсгийн/, 3154-18 Нислэгийн мэдээллийн ажилтан, 3155-12 Радионавигацийн инженер, 3359-22 Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч, 5419-16 Ажилчин /аэродромын, шувуу үргээгч/, 7231-20 Механикч, усан замын тээврийн хэрэгслийн, 7231-21 Оношлогч, автомашины компьютер оношилгооны, 8332-18 Жолооч, тир горимын ачаа тээврийн, 8332-19 Жолооч, аюултай ачаа тээврийн гэж нийт 16 ажил мэргэжил нэмсүгэй.

3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах 6121-12 Малчин, 8153-12 Хатгамалын машины операторч, 8153-13 Хээ тавих машины операторч, 8160-24 Операторч, тос шахах машины гэж 4 ажил мэргэжил нэмж, 6221 нэгж бүлгийн нэршилд өөрчлөлт оруулсугай.


4. Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт 08-ын 2 дугаар хавсралт "Үндэсний ажил, мэргэжлийн индекс/код"-ын зам тээвэр, хүнс хөдөө аж ахуй, боловсрол, хүн ам, нийгмийн хамгааллын байгууллагад хамаарах шинээр нэмж орж байгаа ажил мэргэжил, өөрчлөлтийг энэхүү тушаалын хавсралтаар баталсугай.

5. Зам тээвэр, хүнс хөдөө аж ахуй, боловсрол, хүн ам, нийгмийн хамгааллын байгууллагуудад энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан ажил, мэргэжлийн ангиллын дагуу байгууллагын ажил мэргэжлийн жагсаалт, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, норм норматив тогтоохдоо мөрдөхийг зөвлөсүгэй.

6. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаярт үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

САЙД



А.АРИУНЗАЯА

151201274

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2021 оны 11 дугаар сарын 17-ны
өдрийн 11 дугаар тушаалын хавсралт



13 Үйлдвэрлэл, төрөлжсөн үйлчилгээний менежер

134 Мэргэшсэн үйлчилгээний менежер

1341 Хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээний менежер

1341-04 Хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээний менежер

1341-05 Өдөр өнжүүлэхийн менежер

21 Шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн

214 Инженер мэргэжилтэн (цахим-технологоос бусад)

2144 Механикч инженер

2144-47 Инженер /агаарын хөлгийн гадаргуугийн цанталт арилгах, мөстөлтөөс хамгаалах шингэн цацагч автомашины/

23 Багшлах мэргэжилтэн

232 Техник мэргэжлийн боловсролын багш

2320 Техник мэргэжлийн боловсролын багш

2320-116 Багш, жолооны /усан замын тээврийн хэрэгслийн/

24 Бизнес, захиргааны мэргэжилтэн

242 Захиргааны мэргэжилтэн

2423 Хүмүүний нөөц, ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөгч мэргэжилтэн

2423-18 Ажлын байрны дадлагажуулагч

31 Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн

315 Усан онгоц, агаарын хөлгийн хянагч, техникч

3153 Агаарын хөлгийн нисгэгч, холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн

3153-18 Шалгалтын нислэгийн шалгагч инженер

3154 Агаарын хөдөлгөөн хянагч

3154-13 Инженер /нислэгийн журам зохиогч/

3154-14 Ерөнхий нислэгийн удирдагч

3154-15 Ахлах нислэгийн удирдагч

3154-16 Нислэгийн удирдагч

3154-17 Зохицуулагч /эрэн хайх, авран туслах, мэдээлэл зохицуулах хэсгийн/

3154-18 Нислэгийн мэдээллийн ажилтан

3155 Агаарын хөдөлгөөний аюулгүйн цахим техникч

3155-12 Радионавигацийн инженер

33 Бизнес, удирдлагын туслах мэргэжилтэн

335 Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан

3359 Аль нэг ангилалд ороогүй Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч байгууллагын туслах/дэд мэргэжилтэн

3359-22 Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын байцаагч
3359-23 Бусад

343 Соёл, урлаг, хоолны технологийн туслах/дэд мэргэжилтэн

3434 Шеф тогооч /Chefs/

3434-11 Тэргүүлэх шеф тогооч /Head chef/
3434-12 Ерөнхий шеф тогооч /Executive Chef/
3434-13 Шеф тогооч, торт нарийн боовны

53 Хувь хүн асрамжлах үйлчилгээ

532 Эмнэлгийн сувилгааны ажилтан

5322 Гэрээр асрамжлах үйлчилгээний ажилтан

5322-15 Хөгжлийн бэрхшээлтэй хүний туслах

54 Хамгаалах үйлчилгээний ажилтан

541 Хамгаалах үйлчилгээний ажилтан

5419 Аль нэг ангилалд ороогүй хамгаалах үйлчилгээний бусад ажилтан

5419-16 Ажилтан /аэродромын, шувуу үргээгч/

61 Зах зээлийн баримжаатай хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан

612 Малчин, амьтан маллагч

6121 Мал маллагч, сүү, цагаан идээ үйлдвэрлэгч

6121-11 Мах, цагаан идээ үйлдвэрлэгч
6121-12 Малчин
6121-13 Адуучин
6121-14 Тэмээчин
6121-15 Үхэрчин
6121-16 Хоньчин
6121-17 Ямаачин
6121-18 Гахайчин
6121-19 Муур үржүүлэгч
6121-20 Нохой үржүүлэгч
6121-21 Фермийн ажилтан, мэргэшсэн /сүүний/
6121-22 Фермийн ажилтан, мэргэшсэн /үслэг ангийн/
6121-23 Фермер, ангийн арьс үсний

62 Зах зээлийн баримжаатай ой, загас агнуурын аж ахуйн мэргэшсэн ажилтан

622 Загасны аж ахуйн ажилтан, анчин, гөрөөчин

6221 Усны ургамал ургуулагч, амьтан үржүүлэгч

6221-11 Загас үржүүлгийн ажилтан
6221-12 Загас, усны бусад амьтдын хоол тэжээл бэлтгэх ажилтан
6221-13 Усны бусад амьтан үржүүлгийн ажилтан
6221-14 Усны ургамал ургуулах (актапоник, гидропоник) ажилтан

72 Металл, машин механизм, тэдгээрт холбогдох ажил, мэргэжлийн ажилтан

723 Машин, механизмын механикч, засварчин

7231 Моторт тээврийн хэрэгслийн механикч, тохируулагч

7231-20 Механикч, усан замын тээврийн хэрэгслийн

7231-21 Оношлогч, автомашины компьютер оношилгооны

81 Төхөөрөг, машин механизмын операторч

815 Нэхмэл, үслэг эдлэл, арьс ширэн бүтээгдэхүүний машины операторч

8153 Оёдлын машины операторч

8153-12 Хатгамалын машины операторч

8153-13 Хээ тавих машины операторч

81 Төхөөрөг, машин механизмын операторч

816 Хоол хүнс, бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх машины операторч

8160 Хоол хүнс, бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүний машины операторч

8160- 24 Операторч, тос шахагч машины

83 Жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч

833 Хүнд даацын машин, автобусны жолооч

8332 Хүнд даацын машин, том тэрэгний жолооч

8332-18 Жолооч, тир горимын ачаа тээврийн

8332-19 Жолооч, аюултай ачаа тээврийн